

**АГУУЛГА**

1	Аудитын гэрчилгээ	3
2	Аудитын тайлан	5
2.1	Оршил	5
2.2	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	5
2.3	Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	6
2.4	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	7
2.5	Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	8
2.6	Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	8
2.7	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	8
2.8	Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	9
2.8.1	Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээлэл	9
2.8.2	Залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудал	9
2.9	Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	9
2.10	Үйл ажиллагааны орлого, зардлын төсөв, гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	9
2.11	Шилэн дансны мэдээлэл	11
2.12	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга	1
2.13	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл	1
3	Менэжментийн захидал	1
3.1	Мөнгөн хөрөнгийн данстай холбоотой асуудал	1
3.1.1	Илрүүлэлт	
3.1.2	Эрсдэл	
3.1.3	Өгсөн зөвлөмж	
3.1.4	Байгууллагаас өгсөн хариу, тайлбар	
3.2	Зардлын данстай холбоотой асуудал	
3.2.1	Илрүүлэлт	
3.2.2	Эрсдэл	
3.2.3	Өгсөн зөвлөмж	
3.2.4	Байгууллагаас өгсөн хариу, тайлбар	
3.3	Орлого, үр дүнгийн данстай холбоотой асуудал	
3.3.1	Илрүүлэлт	
3.3.2	Эрсдэл	
3.3.3	Өгсөн зөвлөмж	
3.3.4	Байгууллагаас өгсөн хариу, тайлбар	
4	Аудит хийсэн санхүүгийн тайлан	
4.1	Аудит хийсэн Санхүүгийн байдлын тайлан	
4.2	Аудит хийсэн Орлогын дэлгэрэнгүй тайлан	
4.3	Аудит хийсэн Өмчийн өөрчлөлтийн тайлан	
4.4	Аудит хийсэн Мөнгөн гүйлгээний тайлан	
5	Хавсралт	
5.1	Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт	



## ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг  
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр  
Утас:26-04-37, Факс:62-26-32-30  
E-mail: info@audit.gov.mn

"УЛААНБААТАР ДУЛААНЫ  
СҮЛЖЭЭ" ТӨХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ  
ЗАХИРАЛ Ч.САРАНЖАВ ТАНАА

2019.03.15 № 06/490  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

### Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу "Улаанбаатар дулааны сүлжээ" ТӨХК-ийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, тодруулгад аудит хийв.

### Хязгаарлалттай санал дүгнэлт

Аудитын гол асуудалд дурдсан алдаа, зөрчлийг эс тооцвол "Улаанбаатар дулааны сүлжээ" ТӨХК-ийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайланг материаллаг зүйлсийн хувьд Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох стандартад нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн байна.

### Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар "Улаанбаатар дулааны сүлжээ" ТӨХК-ийн 2018 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

## Аудитын гол асуудал


Тус компани 2018 оны зорилтот түвшний батлагдсан төлөвлөгөөгөөр 98,902.4 сая төгрөгийн борлуулалтын орлоготой ажиллахаас гүйцэтгэлээр 96,256.0 сая төгрөгийн орлого олж, 2,646.4 сая төгрөгөөр тасарсан, улмаар тайлант онд 4,352.2 сая төгрөгийн алдагдалтай ажилласан, 2018 оны эцэст нийт 6,384.1 сая төгрөгийн авлагатай тайлагнаснаас дансны болон бусад авлага өмнөх оноос 2,733.9 сая төгрөгөөр өссөн. Үүнээс 38 байгууллагын 315.6 сая төгрөгийн авлагыг тооцоо нийлж баталгаажуулаагүй, НӨАТ-ын 335.0 сая төгрөгийн маргаантай авлага үүссэн, мөн тайлант онд 5,948.0 сая төгрөгийн дансны өр төлбөр үүссэн, үндсэн ба нэмэгдэл цалин урамшуулал 304.6 сая төгрөгөөр, НДШ 43.8 сая төгрөгөөр, хангамжийн зардал 5.0 сая төгрөгөөр, диспетчерийн үйлчилгээний зардал 35.6 сая төгрөгөөр, харуул хамгаалалтын зардал 3.0 сая төгрөгөөр тус тус төлөвлөснөөс хэтэрсэн зэрэг зөрчлүүд нь санхүүгийн тайлангийн эрх ба үүрэг, үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

## Үүрэг, хариуцлага


"Улаанбаатар дулааны сүлжээ" ТӨХК нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН  
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ



## **2. Аудитын тайлан**

### **2.1 Оршил**

“Улаанбаатар дулааны сүлжээ” ТӨХК-ийн 2018 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлтийг гүйцэтгэх захирал Ч.Саранжав Танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг менежментийн захидалд тусгасан болно.

### **2.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага**

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 8.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу “Улаанбаатар дулааны сүлжээ” ТӨХК-ийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайланд аудит хийлээ.

“Улаанбаатар дулааны сүлжээ” ТӨХК-ийн 2018 оны санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох стандартад нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд санал дүгнэлт гаргах нь энэхүү аудитын зорилт байв.

“Улаанбаатар дулааны сүлжээ” ТӨХК-ийн удирдлага нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг СТОУС болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайланг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2019 оны 01 дүгээр сарын 15-наас 2019 оны 03 дугаар сарын 05-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2019 оны 03 дугаар сарын 15-ны өдөр эцэслэн баталгаажуулж, байгууллагын удирдлагад хүргүүлэхээр төлөвлөн, “Баян суварга Аудит” ХХК-ийн аудитор Х.Тунгалагтуяа хариуцаж хэрэгжүүлэв.

“Улаанбаатар дулааны сүлжээ” ТӨХК-ийн 2018 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг 2019 оны 02 дугаар сарын 15-ны өдрийн 09/171 дүгээр албан бичгээр Үндэсний аудитын газарт ирүүлсэн байна.

### **2.3 Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт**

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБОУС, АОУС-ын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, СТОУС, НББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

## 2.4 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль эрх зүйн орчин

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

"Улаанбаатар дулааны сүлжээ" ТӨХК-ийн талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягтаар баталгаажуулсан болно.

"Улаанбаатар дулааны сүлжээ" ТӨХК нь БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн 1959 оны 09 дүгээр сарын 09-ний өдрийн 367 дугаар тогтоолоор "Улаанбаатар хотын Дулааны шугам сүлжээний газар" нэртэй /"УБДШСГ"/-гээр анх байгуулагдан, Монгол Улсын Засгийн газрын 2001 оны 07 дугаар сарын 09-ний өдрийн 164 дүгээр тогтоолоор "Улаанбаатар дулааны сүлжээ" ТӨХК-ийн хэлбэрт шилжин ажиллаж байна.

Эрхэм зорилго:

"Улаанбаатар дулааны сүлжээ" ТӨХК нь "Найдвартай үр ашигтай ажиллагаа" гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

Үйл ажиллагааны чиглэл:

- Нийслэл хотын төвлөрсөн дулаанд холбогдсон хэрэглэгчдийг дулааны эрчим хүчээр тасралтгүй найдвартай хангах, түгээх, шугам тоноглолын засвар үйлчилгээг чанартай хийж үйлдвэрлэлийг найдвартай явуулах,
- Дулааны эрчим хүчний борлуулалтын үнэ өртгийг бүрэн цуглуулах,
- Дулааны эх үүсвэрт боловсруулсан дулааны эрчим хүчний чанарт байнгын хяналт тавьж алдагдалгүй дамжуулах,
- Төвлөрсөн дулаан хангамжинд шинээр холбогдох хэрэглэгчийн захиалгыг судлан барилга, объектын техникийн нөхцлийг зохих журмын дагуу олгож хэрэгжилтэнд нь хяналт тавих,
- Хэрэглэгчийн дулааны шугам тоноглолын засвар, үйлчилгээг чанартай хийлгэж өвлийн их ачааллыг амжилттай давах, дулааны эрчим хүчний ашиглалтад тогтмол хяналт тавьж зүй бус хэрэглээг бууруулах, хэрэглэгчдэд мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх зэрэг үйлдвэрлэлийн үндсэн үйл ажиллагааг эрхэлж байна.

Тус компани "Амгалан дулааны станц" ХХК, "ДЦС-2" ХК, "ДЦС-3" ХК, "ДЦС-4" ХК-иудын боловсруулсан дулааны эрчим хүчээр Улаанбаатар хотын төвлөрсөн дулаан хангамжийн системд холбогдсон 2760 аж ахуйн гэрээтэй хэрэглэгч, ОСНААУГ-ын харъяа 3 түгээх төвийн Хэрэглэгчид үйлчлэх 16 төвийн 9000 гаруй барилга объектын халаалт, салхилуулга, хэрэгцээний халуун усны 1885.3 Гкал/ц-ийн ачаалал бүхий дулааны эрчим хүчний хэрэглээг өөрийн эзэмшлийн Ф200-Ф1200 мм-ийн голчтой 379.5 км урттай 13 магистраль шугам, насосны 8 станц, дулаан дамжуулах 2 төвөөр дамжуулан жилийн турш тасралтгүй, найдвартай ханган ажиллаж байна.

Компанийн ТУЗ-ийн 2018 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 02 дугаар тогтоолоор зохион байгуулалтын бүтцийн схемийг 14 алба, хэлтэс нэгжтэйгээр шинэчлэн, орон тооны дээд хязгаарыг 360 орон тоотой ажиллахаар баталж, гүйцэтгэлээр 360 орон тоотойгоор үйл ажиллагаагаа явуулсан байна.

"Улаанбаатар дулааны сүлжээ" ТӨХК-ийн үндсэн болон үндсэн бус үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд судалж, баримтжуулсан.

“Улаанбаатар дулааны сүлжээ” ТӨХК-ийн удирдлага дараах хууль болон Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд ТӨБЗГ-аас баталсан зорилтот түвшин бизнес төлөвлөгөөний хэрэгжилт, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Хөдөлмөрийн тухай хууль
- Татварын тухай багц хууль,
- Нийгмийн даатгалын тухай хууль,
- Хэмжлийн нэгдмэл байдлыг хангах тухай хууль,
- Эрчим хүчний тухай хууль
- Эрчим хүч хэмнэлтийн тухай хууль
- Дулааны эрчим хүчээр хангах техникийн нөхцөл олгох журам /Эрчим хүчний сайдын 2013 оны 03 дугаар тушаал/
- “Улаанбаатар дулааны сүлжээ” ТӨХК, хэрэглэгч хоорондын аж ахуйн харилцааны дүрэм /Эрчим хүчний зохицуулах хорооны 2015 оны 317 дугаар тогтоол/
- Эрчим хүчний салбарын 2017-2018 оны хамт /тариф/-ын хэлэлцээр г.м

Тайлант хугацаанд дээрх бодлого, журамд томоохон шинэчлэлт, өөрчлөлт гарсан эсэх талаар дараах заалтад тэмдэглэв.

“Эрчим хүчний зохицуулах хороо /ЭХЗХ/-ноос 2018 онд “Улаанбаатар дулааны сүлжээ” ТӨХК-иас тусгай зөвшөөрөл эзэмшигч нэр бүхий 36 аж ахуйн нэгжид борлуулах бөөний тариф, 33 аж ахуйн нэгжид борлуулах түр тарифыг тус тус баталсан.

Мөн ЭХЗХ-ны 2018 оны 20, 21, 22, 25, 383, 474, 485 дугаар тогтоолуудаар дулааны цахилгаан станцуудаас худалдан авах дулааны тарифыг, 30 дугаар тогтоолоор дулаан түгээх, хангах үйлчилгээний төлбөр буюу тарифыг тус тус шинэчлэн баталсан байна.

## **2.5 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ**

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

“Улаанбаатар дулааны сүлжээ” ТӨХК-ийн Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

“Улаанбаатар дулааны сүлжээ” ТӨХК-ийн санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагааг үнэлэхэд мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

“Улаанбаатар дулааны сүлжээ” ТӨХК-ийн санхүүгийн тайланг бэлтгэхдээ санхүүгийн Интерактив Би Ай ХХК-ийн боловсруулсан нягтлан бодох бүртгэлийн “Даймонд” програм хангамж ашигладаг байна.

“Улаанбаатар дулааны сүлжээ” ТӨХК-ийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

## **2.6 Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал**

Аудитын явцад “Улаанбаатар дулааны сүлжээ” ТӨХК-ийн бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 18 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 6 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

## **2.7 Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар**

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд 2018 оны орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт зардлыг суурь үзүүлэлтээр сонгож, түүний 1 хувиар тооцов.

Аж ахуйн нэгжийн хувьд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгосон нь байгууллагын эдийн засгийн үзүүлэлт, үр дүн нь нийт зардлаас хамааралтай.

“Улаанбаатар дулааны сүлжээ” ТӨХК-ийн 2018 оны нийт зардал 100,710.1 сая төгрөг бөгөөд түүний 1 хувь болох 1,007.1 сая төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын түвшинг Б201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг В401 маягтаар тус тус баримтжуулан баталгаажуулав.

## **2.8 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн**

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.


Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 6 чиглэлээр аудитын 8 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд 4 асуудлыг алдаа, зөрчилтэйд тооцож, 2 асуудлыг алдаа, зөрчилд тооцохгүй гэж шийдвэрлэснээс гадна 3 асуудлыг аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийлгэлээ.

Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээллийг В30103 маягтаар нэгтгэж, баримтжуулсан болно.

### **2.8.1 Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээлэл**

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах асуудлыг залруулан санхүүгийн тайланд тусгаж, “Улаанбаатар дулааны сүлжээ” ТӨХК-ийн удирдлагаар зөвшөөрүүлэн баталгаажуулав. Үүнд:

Завсрын аудитаар актлаж данснаас хассан хөрөнгөтэй холбоотой 1,094.1 сая төгрөгийн, үндсэн хөрөнгийн данстай холбоотой 8,839.0 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснийг залруулсан, мөн 2018 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн өмчийн өөрчлөлтийн тайланд нийт 213.0 сая төгрөгийн залруулага хийлгэсэн болно.



Аудитын явцад илрүүлсэн залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг В501 маягтаар нэгтгэж, баримтжуулсан бөгөөд байгууллагын удирдлага болон холбогдох албан тушаалтнуудад танилцуулж, баталгаажуулсан.

### 2.8.2 Залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудал:

Залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг ангилсан байдал

(сая төгрөгөөр)				
№	Шийдэл	Тоо	Дүн	Тайлбар
1	Зөвлөмж өгсөн	3	4,752.7	
2	Албан шаардлага өгсөн	1	650.6	
	<b>Дүн</b>		<b>5,403.3</b>	

#### 2.8.2.1 Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал

##### Асуудал 1:

Тус компани 2018 оны эцэст нийт 6,384.1 сая төгрөгийн авлагатай тайлагнаснаас дансны болон бусад авлага өмнөх оноос 2,733.9 сая төгрөгөөр өссөн. Үүнээс 38 байгууллагын 315.6 сая төгрөгийн авлагыг тооцоо нийлж баталгаажуулаагүй, НӨАТ-ын 335.0 сая төгрөгийн маргаантай авлага үүссэн, мөн тайлант онд 5,948.0 сая төгрөгийн дансны өр төлбөр үүссэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6-д “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах” гэж заалттай нийцэхгүй байна.

##### Шийдэл:

НӨАТ-ын 335.0 сая төгрөгийн маргаантай авлагыг холбогдох хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэж, 315.6 сая төгрөгийн авлагыг холбогдох байгууллагуудтай тооцоо нийлж баталгаажуулан барагдуулах зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллах талаар Албан шаардлага хүргүүлсэн.

#### 2.9 Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Анхаарал татахуйц бусад чухал асуудал гараагүй болно. Дараагийн аудитаар “Улаанбаатар дулааны сүлжээ” ТӨХК-ийн 2018 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт, хөрөнгийн дахин үнэлгээг нягтлан шалгаж дүгнэх нь зүйтэй гэж үзлээ.

#### 2.10 Үйл ажиллагааны орлого, зардлын төсөв, гүйцэтгэлийн талаарх тайлбар

“Улаанбаатар дулааны сүлжээ” ТӨХК-ийн гүйцэтгэх захирал нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 19 дүгээр зүйлд заасны дагуу үр дүнгийн гэрээгээр хүлээсэн үүргийг биелүүлэх, тайлагнах, мөн хуулийн 20 дугаар зүйлд заасны дагуу эрх, үүргийг хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудитаар компанийн гүйцэтгэх захирал нь зорилтот түвшин, төлөвлөгөөний биелэлтийг зохих журмын дагуу зохион байгуулсан, үнэн зөв, тайлагнасан эсэхэд үнэлэлт өгөхийг зорьдог.

“Улаанбаатар дулааны сүлжээ” ТӨХК-ийн чиг үүргээ хэрэгжүүлэхтэй нь холбоотой 3 багц хөтөлбөр, 82 арга хэмжээнд зориулан 2018 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшинг Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2017 оны 678 дугаар тогтоолоор баталсан байна.

Зорилтот түвшний төлөвлөгөөгөөр 2018 онд 98,902.4 сая төгрөгийн орлого олж, 98,374.7 сая төгрөгийн зардал гарган, 527.7 сая төгрөгийн татвар төлөхийн өмнөх ашигтай ажиллахаар төлөвлөсөн бөгөөд гүйцэтгэлээр 96,256.0 сая төгрөгийн борлуулалтын орлого олж, 100,575.5 сая төгрөгийн зардал гаргаж, 4,319.5 сая төгрөгийн татвар төлөхийн өмнөх алдагдалтай ажиллаж, аж ахуйн нэгжийн орлогын албан татварын зардалд 32.7 сая төгрөг төлөхөөр гарч 4,352.2 сая төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

Энэ нь тайлант онд хэрэглэгчдэд борлуулах 1 Гкал-ын дулааны эрчим хүчний өртөгийг дунджаар 17,665.90 төгрөгөөр тооцон төлөвлөж, гүйцэтгэлээр 16,519.40 төгрөг болж, орлого төлөвлөснөөс 3,330.6 сая төгрөгөөр буурсантай холбоотой байна.

### **2.11 Шилэн дансны мэдээлэл**

“Улаанбаатар дулааны сүлжээ” ТӨХК нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

2018 онд нийт 2 ангиллаар 7 төрлийн 474 мэдээллийг хуулийн хугацаанд цахим хуудсанд байршуулсан байна.

Тус байгууллагын Шилэн дансны хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд үзэхэд хянаж, баримтжуулсан болно.

### **2.12 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга**

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар 4 зөвлөмж, өгсөнөөс 2 зөвлөмжийг бүрэн, 2 зөвлөмжийг 85.0 хувиар хэрэгжүүлж ажилласан байна.

Эдгээр зөвлөмжийн биелэлтийн талаарх мэдээллийг ажлын баримт материалд хадгалсан бөгөөд гүйцэтгэлийг аудитын явцад дахин нягталсан болно.

### **2.13 Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл**

Бид “Улаанбаатар дулааны сүлжээ” ТӨХК-ийн 2018 оны санхүүгийн тайланд аудит хийхдээ АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

“Улаанбаатар дулааны сүлжээ” ТӨХК 2018 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн тайлан болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдийг холбогдох хууль, стандартад нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

### **3 МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ**

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь “Улаанбаатар дулааны сүлжээ” ТӨХК-ийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

#### **3.1 Мөнгөн хөрөнгийн данстай холбоотой асуудал**

##### **3.1.1 Илрүүлэлт:**

Тус компанийн кассаас дараа тайлангаар шинэ жил, сургалтын зардалд зориулан авсан 8.9 сая төгрөгийг анхан шатны баримтын бүрдэл дутуу шууд зардлаар тайлагнасан байна.

Энэ нь “Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль”-ийн 13 дугаар зүйлийн 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно” гэж заасантай нийцэхгүй байна.

##### **3.1.2 Эрсдэл:**

Мөнгөн хөрөнгийн зарцуулалтад тавих дотоод хяналт суларч, үргүй зардал гаргах, бэлэн мөнгө ашиглах, шамшигдуулах.

##### **3.1.3 Өгсөн зөвлөмж:**

Цаашид дараа тайлангаар авсан бэлэн мөнгөний зарцуулалтын анхан шатны баримтын бүрдүүлэлт, тайлан тооцоонд тавих хяналтыг сайжруулж ажиллах.

##### **3.1.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:**

Аудитын зөвлөмжийн дагуу холбогдох арга хэмжээг авч, хариу мэдэгдэнэ.

#### **3.2 Зардлын данстай холбоотой асуудал**

##### **3.2.1 Илрүүлэлт:**

2018 онд түгээх, хангах үйл ажиллагааны зардлыг батлагдсан төлөвлөгөөнөөс нийт дүнгээр 113.6 сая төгрөгөөр хэмнэлттэй зарцуулсан боловч зардлын ангиллаар авч үзвэл үндсэн ба нэмэгдэл цалин урамшуулал 304.6 сая төгрөгөөр, НДШ 43.8 сая төгрөгөөр, хангамжийн зардал 5.0 сая төгрөгөөр, диспетчерийн үйлчилгээний зардал 35.6 сая төгрөгөөр, харуул хамгаалалтын зардал 3.0 сая төгрөгөөр тус тус төлөвлөснөөс хэтэрсэн байна.

### 3.2.2 Эрсдэл:

Зардлын тайлан тооцоонд тавих хяналт суларч, холбогдох эрхийн акт зөрчигдөх.

### 3.2.3 Өгсөн зөвлөмж:

Орлого, зардлын төлөвлөгөөг тухайн жилийн үйл ажиллагааны хөтөлбөр, арга хэмжээтэй уялдуулан үндэслэлтэй төлөвлөх, батлагдсан зардлын зарцуулалтад тавих хяналтыг сайжруулж, үр ашиггүй зардал гаргахгүй ажиллах.

### 3.2.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Аудитын зөвлөмжийн дагуу холбогдох арга хэмжээг авч, хариу мэдэгдэнэ.

## 3.3 Орлого, үр дүнгийн данстай холбоотой асуудал

### 3.3.1 Илрүүлэлт:

Тус компани 2018 оны зорилтот түвшний батлагдсан төлөвлөгөөгөөр борлуулалтын орлого 98,902.4 сая төгрөгөөр батлагдсанаас гүйцэтгэлээр 96,256.0 сая төгрөгийн орлого олж, 2,646.4 сая төгрөгөөр тасарсан нь тайлант оны үр дүнд нөлөөлж 4,352.2 сая төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

### 3.3.2 Эрсдэл:

Компанийн алдагдал өсч, дулааны эрчим хүчний авлага, өр төлбөр ихсэх, харилцагч байгууллагуудын эдийн засгийн үр ашигт сөргөөр нөлөөлөх.

### 3.3.3 Өгсөн зөвлөмж:

Дулааны цахилгаан станцуудаас худалдан авах дулааны эрчим хүчний 1Гкал-ын өртгийг бууруулах, хэрэглэгчдэд борлуулах дулааны эрчим хүчний үнэ тарифыг зохистой хэмжээнд өсгөж, улмаар компанийг алдагдалгүй ажиллуулах асуудлыг Эрчим хүчний яам, ТӨБЗГ, Эрчим хүчний зохицуулах хороонд дахин яаралтай тавьж шийдвэрлүүлэх.

### 3.3.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Аудитын зөвлөмжийн дагуу холбогдох арга хэмжээг авч, хариу мэдэгдэнэ.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2019 оны 6 дугаар сарын 30-ны дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

#### 4. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

##### 4.1 Аудит хийсэн 2018 оны Санхүүгийн байдлын тайлан

2018 оны 12 дугаар сарын 31-нээр дуусвар болсон тайлант жил

Балансын зүйл	<i>/төгрөгөөр/</i>	
	2017 оны 12 дугаар сарын 31	2018 оны 12 дугаар сарын 31
<b>ХӨРӨНГӨ</b>		
<b>Эргэлтийн хөрөнгө</b>		
Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө	2,216,782,812.49	1,009,805,060.97
Дансны авлага	1,083,231,848.52	3,486,984,543.56
Татвар, НДШ-ийн авлага	720,584,788.78	1,022,920,804.68
Бусад авлага	1,846,522,963.30	1,874,344,902.90
Бусад санхүүгийн хөрөнгө	-	-
Бараа материал	508,066,712.77	639,848,937.37
Урьдчилж төлсөн зардал тооцоо	238,816,854.95	121,004,729.44
Бусад эргэлтийн хөрөнгө	-	-
<b>Эргэлтийн хөрөнгийн дүн</b>	<b>6,614,005,980.81</b>	<b>8,154,908,978.92</b>
<b>Эргэлтийн бус хөрөнгө</b>		
Үндсэн хөрөнгө	150,851,554,426.55	193,729,774,362.57
Биет бус хөрөнгө	93,277,879.02	2,124,050,975.64
Биологийн хөрөнгө	-	-
Урт хугацаат хөрөнгө оруулалт	14,630,123,325.17	13,488,103,381.81
Хайгуул ба үнэлгээний хөрөнгө	-	-
Хойшлогдсон татварын хөрөнгө	736,448,822.26	736,448,822.26
Хөрөнгө орлуулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө	-	-
Бусад эргэлтийн бус хөрөнгө	-	-
<b>Эргэлтийн бус хөрөнгийн дүн</b>	<b>166,311,404,453.00</b>	<b>210,078,377,542.28</b>
<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>172,925,410,433.81</b>	<b>218,233,286,521.20</b>
<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ</b>		
<b>ӨР ТӨЛБӨР</b>		
<b>Богино хугацаат өр төлбөр</b>		
Дансны өглөг	-	5,797,337,127.39
Цалингийн өглөг	-	-
Татварын өр	86,664,865.97	5,644,371.00
НДШ-ийн өглөг	-	-
Богино хугацаат зээл	-	-
Хүүний өглөг	-	-
Ногдол ашгийн өглөг	-	-
Урьдчилж орсон орлого	157,657,050.50	211,164,333.13
Нөөц /өр төлбөр /	-	-
Бусад богино хугацаат өр төлбөр	96,933,572.00	275,198,687.00
<b>Богино хугацаат өр төлбөрийн дүн</b>	<b>341,255,488.47</b>	<b>6,289,344,518.52</b>
<b>Урт хугацаат өр төлбөр</b>		
Урт хугацаат зээл	21,642,629,024.07	20,137,819,521.07
Нөөц /өр төлбөр/	-	-
Хойшлогдсон татварын өр	-	-
Бусад урт хугацаат өр төлбөр	1,469,841,771.00	1,872,506,845.26

"Улаанбаатар дулааны сүлжээ" ТӨХК-ийн 2018 оны санхүүгийн тайлангийн аудит

Урт хугацаат өр төлбөрийн дүн	23,112,470,795.07	22,010,326,366.33
Өр төлбөрийн нийт дүн	23,453,726,283.54	28,299,670,884.85
Эздийн өмч	-	-
Төрийн өмч	123,273,508,753.71	133,086,185,117.05
Хувийн өмч	-	-
Хувьцаат өр төлбөр	-	-
Халаасны хувьцаа	-	-
Нэмж төлөгдсөн капитал	10,651,725,701.30	41,445,006,176.41
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	16,905,316,328.48	19,227,515,025.53
Төсвийн санхүүжилт		
Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц	-	-
Эздийн өмчийн бусад хэсэг	-	2,051,204,420.00
Хуримтлагдсан ашиг	(1,358,866,633.22)	(5,876,295,102.64)
Эздийн өмчийн дүн	149,471,684,150.27	189,933,615,636.35
<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ</b>	<b>172,925,410,433.81</b>	<b>218,233,286,521.20</b>

### 4.3 Аудит хийсэн 2018 оны Өмчийн өөрчлөлтийн тайлан

2018 оны 12 дугаар сарын 31-нээр дуусвар болсон тайлант жил

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмч	Нэмж төлөгдсөн капитал	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
<b>2016 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл</b>	<b>100,866,295,643.12</b>	<b>22,407,213,110.59</b>	<b>17,179,128,646.48</b>	-	<b>(1,902,494,964.19)</b>	<b>138,550,142,436.00</b>
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	22,407,213,110.59	-	-	-	-	22,407,213,110.59
<b>Залруулсан үлдэгдэл</b>	<b>123,273,508,753.71</b>	<b>22,407,213,110.59</b>	<b>17,179,128,646.48</b>	-	<b>(1,902,494,964.19)</b>	<b>160,957,355,546.59</b>
Бусад дэлгэрэнгүй орлого	-	10,651,725,701.30	-	-	-	10,651,725,701.30
Өмчид гаргасан өөрчлөлт	-	(22,407,213,110.59)	-	-	-	(22,407,213,110.59)
Зарласан ногдол ашиг	-	-	-	-	(743,378,040.00)	(743,378,040.00)
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	-	-	1,013,194,052.97	1,013,194,052.97
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	-	-	(273,812,318.00)	-	273,812,318.00	-
<b>2017 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл</b>	<b>123,273,508,753.71</b>	<b>10,651,725,701.30</b>	<b>16,905,316,328.48</b>	-	<b>(1,358,866,633.22)</b>	<b>149,471,684,150.27</b>
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	10,651,725,701.30	-	-	-	-	10,651,725,701.30
<b>Залруулсан үлдэгдэл</b>	<b>133,925,234,455.01</b>	<b>10,651,725,701.30</b>	<b>16,905,316,328.48</b>	-	<b>(1,358,866,633.22)</b>	<b>160,123,409,851.57</b>
Бусад дэлгэрэнгүй орлого	-	41,445,006,176.41	-	2,051,204,420.00	-	43,496,210,596.41
Өмчид гаргасан өөрчлөлт	(839,049,337.96)	(10,651,725,701.30)	-	-	(146,624,356.00)	(11,637,399,395.26)
Зарласан ногдол ашиг	-	-	-	-	-	-
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	-	-	(4,352,219,809.63)	(4,352,219,809.63)
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	-	-	2,322,198,697.05	-	(18,584,303.79)	2,303,614,393.26
<b>2018 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл</b>	<b>133,086,185,117.05</b>	<b>41,445,006,176.41</b>	<b>19,227,515,025.53</b>	<b>2,051,204,420.00</b>	<b>(5,876,295,102.64)</b>	<b>189,933,615,636.35</b>

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА  
ХЯЭГААРЛАЛТАЙ  
САНАЛ ДҮГНЭЭЛТ

#### 4.4 Аудит хийсэн 2018 оны Мөнгөн гүйлгээний тайлан

2018 оны 12 дугаар сарын 31-нээр дуусвар болсон тайлант жил

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
<b>Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
<b>Мөнгөн орлогын дүн (+)</b>	<b>102,193,543,856.18</b>	<b>103,120,842,001.77</b>
Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсэний орлого	101,695,931,681.15	102,787,583,899.59
Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого	-	-
Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	-	-
Буцаан авсан албан татвар	-	-
Татаас, санхүүжилтийн орлого	-	-
Бусад мөнгөн орлого	497,612,175.03	333,258,102.18
<b>Мөнгөн зарлагын дүн (-)</b>	<b>(92,975,307,640.98)</b>	<b>(95,242,269,664.37)</b>
Ажиллагчдад төлсөн	(7,008,022,822.00)	(7,416,666,071.00)
Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	(1,893,772,226.06)	(2,177,356,583.85)
Бараа материал худалдан авахад төлсөн	(926,172,303.72)	(967,126,200.70)
Ашиглалтын зардалд төлсөн	(1,721,231,183.96)	(1,612,908,586.56)
Түлш, шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	-	-
Хүүний төлбөрт төлсөн	-	-
Татварын байгууллагад төлсөн	(2,819,123,167.71)	(2,801,947,652.13)
Даатгалын төлбөрт төлсөн	-	-
Бусад мөнгөн зарлага	(78,606,985,937.53)	(80,266,264,570.13)
<b>Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>9,218,236,215.20</b>	<b>7,878,572,337.40</b>
<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
<b>Мөнгөн орлогын дүн (+)</b>		<b>6,841,217.00</b>
Үндсэн хөрөнгө борлуулсаны орлого		-
Биет бус хөрөнгө борлуулсаны орлого		-
Хөрөнгө оруулалт борлуулсаны орлого		6,841,217.00
Хүлээн авсан хүүний орлого		-
Хүлээн авсан ногдол ашиг		-
<b>Мөнгөн зарлагын дүн (-)</b>	<b>(9,488,516,330.57)</b>	<b>(8,973,322,213.14)</b>
Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	(7,466,788,329.00)	(6,992,074,335.50)
Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	-	-
Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн	-	-
Бусад урт хугацаат хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	(2,021,728,001.57)	(1,981,247,877.64)
Бусдад олгосон зээл болон урьдчилгаа	-	-
<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>(9,488,516,330.57)</b>	<b>(8,966,480,996.14)</b>
<b>Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
<b>Мөнгөн орлогын дүн (+)</b>	<b>311,977.13</b>	<b>357,267.58</b>
Төрөл бүрийн хандив	-	-
Валютын ханшийн тэгшитгэлийн ашиг	311,977.13	357,267.58
<b>Мөнгөн зарлагын дүн (-)</b>	<b>(743,780,020.18)</b>	<b>(119,426,360.36)</b>
Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн	-	-
Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн	-	-
Хувьцаа буцаан худалдаж төлсөн	-	-
Төлсөн ногдол ашиг	(743,378,040.00)	(119,343,141.00)
Валютын ханшийн тэгшитгэлийн алдагдал	(401,980.18)	(83,219.36)
<b>Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>(743,468,043.05)</b>	<b>(119,069,092.78)</b>

<b>Бүх цэвэр мөнгөн гүйлгээ</b>	<b>(1,013,748,158.42)</b>	<b>(1,206,977,751.52)</b>
<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>3,230,530,970.91</b>	<b>2,216,782,812.49</b>
<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>2,216,782,812.49</b>	<b>1,009,805,060.97</b>

## 5. ХАВСРАЛТ

### 5.1 Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	Аудитын нэр:	“Улаанбаатар дулааны сүлжээ” ТӨХК-ийн 2018 оны санхүүгийн тайлангийн аудит	Аудитын код:
2019.03.15			САГ-2019/114/СТА-ТӨҮГ
Шалгагдсан байгууллагын нэр:	“Улаанбаатар дулааны сүлжээ” ТӨХК		сая төгрөгөөр

№	Аудитын чиглэл	Тоо	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Үйлчлүүлэгч байгууллагын талаас алдаа, зөрчилтэй асуудлыг хариуцах хүний	
						Албан тушаал	Овог нэр
A	1	2	3	4	5	6	7
1	Мөнгөн хөрөнгийн данстай холбоотой асуудал	1	Кассаас дараа тайлангаар шинэ жил, сургалтын зардалд зориулан авсан 8,940.0 мянган төгрөгийг анхан шатны баримтын бүрдэлгүйгээр шууд зардлаар тайлагнасан байна.	8.9	Зөвлөмж өгөх	Гүйцэтгэх захирал, Санхүү бүртгэлийн хэлтсийн дарга бөгөөд Ерөнхий нягтлан бодогч	Ч.Саранжав, И.Шүрэнцэцэг
2	Авлага, өр төлбөрийн данстай холбоотой асуудал	1	Тус компани 2018 оны эцэст нийт 6,384.1 сая төгрөгийн авлагатай тайлагнаснаас дансны болон бусад авлага өмнөх оноос 2,733.9 сая төгрөгөөр өссөн. Үүнээс 38 байгууллагын 315.6 сая төгрөгийн авлагыг тооцоо нийлж баталгаажуулаагүй, НӨАТ-ын 335.0 сая төгрөгийн маргаантай авлага үүссэн, мөн тайлант онд 5,948.0 сая төгрөгийн дансны өр төлбөр үүссэн байна.	650.6	Албан шаардлага	Гүйцэтгэх захирал, Санхүү бүртгэлийн хэлтсийн дарга бөгөөд Ерөнхий нягтлан бодогч	Ч.Саранжав, И.Шүрэнцэцэг
3	Зардлын данстай холбоотой асуудал	1	2018 онд түгээх, хангах үйл ажиллагааны зардлыг батлагдсан төлөвлөгөөнөөс нийт дүнгээр 113.6 сая төгрөгөөр хэмнэлттэй зарцуулсан боловч зардлын ангиллаар авч үзвэл үндсэн ба нэмэгдэл цалин урамшуулал 304.6 сая төгрөгөөр, НДШ 43.8 сая төгрөгөөр, хангамжийн зардал 5.0 сая төгрөгөөр, диспетчерийн үйлчилгээний зардал 35.6 сая төгрөгөөр, харуул хамгаалалтын зардал 3.0 сая төгрөгөөр тус тус төлөвлөснөөс хэтэрсэн байна.	392.0	Зөвлөмж өгөх	Гүйцэтгэх захирал, Санхүү бүртгэлийн хэлтсийн дарга бөгөөд Ерөнхий нягтлан бодогч	Ч.Саранжав, И.Шүрэнцэцэг
4	Орлого, үр дүнгийн данстай холбоотой асуудал	1	Тус компани 2018 оны зорилтот түвшний батлагдсан төлөвлөгөөгөөр 98,902.4 сая төгрөгийн борлуулалтын орлоготой ажиллахаас гүйцэтгэлээр 96,256.0 сая төгрөгийн орлого олж, 2,646.4 сая төгрөгөөр тасарсан, улмаар тайлант онд 4,352.2 сая төгрөгийн алдагдалтай ажилласан байна.	4,352.0	Зөвлөмж өгөх	Гүйцэтгэх захирал, Санхүү бүртгэлийн хэлтсийн дарга бөгөөд Ерөнхий нягтлан бодогч	Ч.Саранжав, И.Шүрэнцэцэг
<b>Дүн</b>		<b>4</b>		<b>5,403.5</b>			